



## ЦАЛИН УРАМШУУЛЛЫН БОДЛОГО

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү баримт бичгийг Монгол Улсын Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексын хүрээнд нийцүүлэн боловсруулав.
- 1.2 Энэхүү бодлогын зорилго нь Бодь Даатгал ХК (цаашид “компани” гэх )-ийн цалин, урамшууллын зарчим, хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлоход оршино.

### Хоёр. Цалин урамшуулал тогтооход баримтлах зарчим

Цалин урамшууллын талаар компанийн хэмжээнд баримтлах бодлогыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтлана.

- 2.1 Ижил үнэлэмж бүхий хөдөлмөрт адил цалин, урамшуулал олгох
- 2.2 Цалин урамшууллын хуваарилалтад аливаа ялгаварлал, гадуурхалгүй байх, тэгш бус байдлыг хязгаарлах
- 2.3 Цалин урамшууллыг ур чадвар болон ажлын үнэлгээ, гүйцэтгэл, үр дунд суурилж тогтоох
- 2.4 Хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн өсөлтийн зохистой харьцаа болон инфляцийн түвшинтэй уялдуулж бодит цалингийн өсөлтийг хангах

### Гурав. Цалин урамшууллын талаар хэрэгжүүлэх ажил

- 3.1 ТҮЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо нь компанийн эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах, холбогдох хууль тогтоомж болон ТҮЗ-аас тодорхойлсон бусад асуудлын хүрээнд дараах хэлбэрээр, зохистой хэмжээг тогтооно.
  - 3.1.1 Тогтмол цалин
  - 3.1.2 Хуралд оролцсон цалин
  - 3.1.3 Компанийн жилийн үр дүнг үндэслэн нэг удаа олгох урамшуулалт цалин
  - 3.1.4 Хорооны үйл ажиллагаанд оролцсон тохиолдолд олгох цалин
  - 3.1.5 Мэргэжлийн өндөр ур чадвартай гүйцэтгэх удирдлагыг тогтвортой суурьшилтай ажиллуулах, идэвхижүүлэхдээ хангалттай цалин, урамшууллын хэмжээг тогтоох
  - 3.1.6 Компанийн үр ашгийг нэмэгдүүлэхдээ бодитой хувь нэмэр оруулсан эсэхийг

харгалзан үзэх

- 3.1.7 Компанийн үйл ажиллагааны чиглэл болон бусад нөхцөл байдлаас шалтгаалан өөр хэлбэрийг харгалзан үзэх
- 3.2 Цалин урамшууллын хороо нь эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг ТУЗ-аар батлуулж, хэрэгжилтэнд нь хяналт тавих, холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргана.
- 3.3 Цалин урамшууллын хороо нь компанийн ажилтны цалин, урамшуулалтай холбоотой дүрэм журам, системийн үр дүнг үнэлж, холбогдох хууль тогтоомжинд нийцэж буй байдалд хяналт тавих, компанийн цалингийн бодлого, түвшин, бүтэц, цалин тогтоох журамд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг ТУЗ-д илтгэж, ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлнэ.

#### **Дөрөв. Бусад**

- 4.1 Шаардлагатай тохиолдолд цалин урамшууллын бодлогын нэмэлт өөрчлөлтийг Цалин урамшууллын хорооноос хянан боловсруулж төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулна.